



ДАРЬГАНГЫН БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗРЫН СУУРИН БОЛОН НҮҮДЛИЙН ШУВУУДЫН СУДАЛГАА



ЗАХИАЛАГЧ:

**ДАРЬГАНГЫН БАЙГАЛИЙН
ЦОГЦОЛБОРТ ГАЗРЫН
ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГАА**

**ДАРЬГАНГЫН БАЙГАЛИЙН
ЦОГЦОЛБОРТ ГАЗРЫН СУУРИН
БОЛОН НҮҮДЛИЙН ШУВУУДЫН
СУДАЛГАА**

Гүйцэтгэсэн:

**Эко түлхүүр ХХК
магистр С.Түвшинтөгс**

Зургийн жагсаалт

Зураг 1. Дарьгангын БЦГ-йн газрын зураг.	5
Зураг 2. Дарьгангын байгалийн цогцолборт газар тохиолсон нийт шувуудын зүйлүүдийг хамаарах багийн түвшинд харьцангуй элбэгшилээр нь харуулсан харьцуулалт.	6
Зураг 3. Дарьгангын байгалийн цогцолборт газрын шувуудын оршин амьдрах хэлбэр.....	7
Зураг 4. Дарьгангын БЦГ-ын шувуудын олон улс дахь ховордлын зэрэг.	7
Зураг 5. Дарьгангын БЦГ-ын шувуудын бүс нутаг дахь ховордлын зэрэг.	7
Зураг 6. Судалгааны үед тохиолдсон Цагаан дэвлээн ганц бодгаль. Зургийг С.Түвшинтөгс	0
Зураг 7. Судалгааны үед тохиолдсон Хурган шунгуур. Зургийг С.Түвшинтөгс	1
Зураг 8. Судалгааны үед Ганга нуурын орчимд тохиолдсон Хар тодол. Зургийг С.Түвшинтөгс	1
Зураг 9. Судалгааны үед тохиолдсон Энхэт бялзуухайн ганц бодгаль. Зургийг С.Түвшинтөгс	2
Зураг 10. Судалгааны үед тохиолдсон Дуулгат бужирга. Зургийг С.Түвшинтөгс ..	2
Зураг 11. Судалгааны үед Молцог элсэнд тохиолдсон Үүрэн сүүлт зана. Зургийг С.Түвшинтөгс	3
Зураг 12. Судалгааны үед Молцог элсэнд тохиолдсон Эгэл занын эм шувуу. Зургийг С.Түвшинтөгс.....	3
Зураг 13. Судалгааны үед тохиолдсон Сондуу хөмрөг. Зургийг С.Түвшинтөгс ...	4
Зураг 14. Судалгааны үед Ганга нуур орчмын бургаст нугаар тохиолдсон Шар хөмсөгт хөмрөг. Зургийг С.Түвшинтөгс	4

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Дарьгангын БЦГ-т тохиолдох олон улсын болоод бүс нутгийн хэмжээнд ховордлын зэрэгт тооцогдох шувуудын зүйлүүд.	0
Хүснэгт 2. Дарьгангын байгалийн цогцолборт газарт уг судалгаагаар бүртгэгдсэн шувуудийн зүйлийн бүрдэлийн жагсаалт. Зөвхөн тус бүс нутагт тохиолдох байдлаар нь доорх байдлаар ангилсан болно. 3-зусдаг, С-суурин, НТ-нүүдлийн үедээ тохиолддог, Ү-үрждэг, Ө-өвөлждөг.	0

Удиртгал

Дарьгангын байгалийн цогцолборт газар нь Монгол орны шувуудын газар зүйн тархалтын мужлалаар Дорнод Монголын хээрийн бүсэд хамаарагдана (Цэгмид 1969).

Дарьгангын БЦГ нь бүхэлдээ Дарьгангын тэгш өндөрлөгт хамаарах бөгөөд далайн түвшинээс дээш 1240-1530 м хүртэл өндөрт өргөгдсөн. Хамгийн өндөр цэг нь Гангын цагаан овоо ба далайн түвшинээс 1530 м өндөр юм. Цогцолборт газрын ихэнх хувийг Молцог элс эзлэн орших бөгөөд өвч ургамлаар бэхлэгдсэн элсэн толгодуудаас бүрдэнэ. Элсний зах болон манхан дотор бургас, хайлаасан ой ургадаг нь тал хээр, ойн олон зүйлийн шувуудын үрждэг, зусдаг мөн өвөлждөг таатай амьдрах орчин болоод зогсохгүй хавар намрын улиралд нүүдлийн шувуудийн дамжин өнгөрөх, амрах, хооллох гол түшиц нутаг болдог. Мөн элсэн дунд болон түүний зах хөвөөгөөр орших Дуут, Зэгст, Баянбүрд, Намжилбүрд, Устбүрд, Эрдэнэ, Сүмт, Ганга, Холбоо, Хошмог зэрэг олон нуурууд нь зүйл бүрийн усны болоод эргийн шувуудын хувьд мөн л ялгаагүй үржих, зусах, дамжин өнгөрөх, хавар намрын нүүдлийн үедээ олноороо цугларах гол түшиц газар болсоор байна. Ийм ч үүднээс “Олон улсын ус намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчныг хамгаалах тухай Рамсарын олон улсын конвенци”, “Олон улсын Шувуудад чухал газар”-ын шалгуурыг хангаж албан ёсоор тус тус бүртгэгдсэн зэрэг нь Дарьгангын БЦГ нь жигүүртэний хувьд зөвхөн манай орон төдийгүй олон улсын хувьд чухал ач холбогдолтой газар гэдэг нь бэлхэнээ харагдаж байна.

Дэлхийд нүүдлийн шувуудын 6 гол зам байдаг бөгөөд эдгээрийн 3 зам нь манай ороны нутаг дэвсгэрт орж ирэн нийлдэг байна. Дарьгангын байгалийн цогцолборт газрын хувьд Зүүн Ази-Австралийн нүүдлийн шувуудын замд хамаарна.

Рамсарын конвенцид бүртгэгдсэн байдал

“Олон улсын ач холбогдол бүхий ус намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчныг хамгаалах тухай” олон улсын конвенцид (Рамсар, Иран, 1971) манай улс 1998 онд нэгдэн орсон. Одоогийн байдлаар нийтдээ 147 орны 129.2 сая га газрыг хамарсан 1524 газар байдгаас, Монгол Улсын 1.7 сая га газрыг хамарсан 11 газар бүртгэгдсэний нэг нь Дарьгангын БЦГ дахь Ганга

нуур юм. Ганга нуурыг энэхүү конвенцид 2004 оны 03 сарын 22-нд 2MN009 №1378 дугаартай бүртгэсэн.

Шувуудад чухал газар болох нь

Олон улсын шувуунд чухал газруудыг “Bird life international” олон улсын байгууллага бүртгэдэг бөгөөд дараах шалгууруудыг харгалздаг байна. Үүнд: A1: Дэлхийн хэмжээнд устах аюулд орсон зүйлүүд A2: Тархалт нутаг хязгаарлагдмал зүйл A3: Биом хязгаарлагдмал газар A4i: Олон улсын ач холбогдол бүхий цугларалт. зэрэг юм. Монгол орны 8.4 сая га талбай бүхий 70 газрыг дээрх шалгуураар бүртгэсэн нь нийт нутаг дэвсгэрийн 5 хувь болдог. Үүнээс Ганга нуурыг (талбайн хэмжээ 26,841 га) MN061 код, A1, A3, A4i шалгуурын дагуу “Тал хээрийн” ус намгархаг газар гэсэн тодорхойлолтоор 2004 онд бүртгэсэн байна.

Судлагдсан байдал

Дарьгангын байгалийн цогцолборт газрын шувуудын судалгаа сүүлийн жилүүдэд нэг бус удаа хийгдсэн байна. Цэвээнмядаг нар (2012)-ын нэгэн тайланд Ганга нуур орчимд 110 гаруй шувуу бүртгэгдсэнээс суурин амьдардаг 12, нүүдлийн 99 зүйл байгаагаас энэ нутагт 32 зүйл нь өндөглөн зусдаг, 62 зүйл нь дайрч өнгөрдөг хэмээн дурьджээ. Харин Дарьгангын байгалийн цогцолборт газрын менежментийн төлөвлөгөө (2013-2017)-д тус газрын шувуудийн талаар дурьдахдаа дээрх мэдээнээс иш татан хэргэлсэн байна. Харин Ганхуяг нар (2013)-ын Ганга нуур болон түүний орчмын Зэгст, Дуут нуурууд, Молцог элсэнд хийсэн шувуудын ажиглалтаар 60 зүйл шувуу бүртгэжээ. Үүнээс 48 зүйл нь нүүдлийн, 9 зүйл нь суурин, 3 зүйл шувуу өвөлждөг хэмээн оршин амьдрах хэлбэрээр нь ангилан гаргажээ. Мөн Түвшинтөгс нар (2013)-ын “Дарьгангын байгалийн цогцолборт газрын зэрлэг амьтдын тархалт элбэгшилийн судалгаа” тайланд хээрийн судалгаа, ажиглалтаар бүртгэсэн болон хэвлэгдсэн бүтээлд тус бүс нутагт тохиолдох боломжтойг тэмдэглэсэн шувуудийн зүйлүүдийг нэгтгэж жагсаалт гаргасан байна. Үүний үр дүнд Дарьганга сум болон Дарьгангын байгалийн цогцолборт газрын хэмжээнд 24 овгийн 94 төрөлд хамаарах 175 зүйл шувуу тохиолдох боломжтойг харуулж, тус бүс нутагт тохиолдох байдлаар авч үзэхэд зусдаг 15, Нүүдлийн зусдаг 10, Суурин 18, Нүүдлийн үедээ тохиолддог 129, Өвөлжих үедээ орж ирдэг 5 зүйл хэмээн

ангилжээ. Мөн тус судалгааны явцад тус газарт хийгдсэн өмнөх судалгааны ажлаар бүртгэгдээгүй Цагаан дэглий (*Egretta alba*), Номин гургалдай (*Luscinia cyane*) Соотон гуйванга (*Asio otus*), Хар өрөвтас (*Ciconia nigra*) зэрэг шувуудыг ажиглалтын явцад шинээр нэмж бүртгэсэн байна.

Судалгааны зорилго, зорилт

Судалгааны зорилго: Дарьгангын байгалийн цогцолборт газрын шувуудын зүйлийн бүрдлийг бүртгэх, Дарьгангын шувуудын зүйлийн бүрдлийг нэмэгдүүлэх, тэдгээрийн оршин амьдрах хэлбэрийг тодорхойлход оршино.

Судалгааны ажлын зорилт:

- Хээрийн судалгаагаар тохиолдсон зүйлүүдийг бүртгэж жагсаалт гаргах,
- Тохиолдсон шувуудын тархалтыг цэгэн байдлаар газрын зурагт буулгах
- Шувуудыг ховор, ховордож байгаа болон амьдралын хэлбэр тус бүрээр нь ангилах
- Тохиолдсон шувуудын зургийг авах

Судалгааны арга зүй


Сүхбаатар аймгийн Дарьганга, Наран сумдын нутгийг дамнан оршдог Дарьгангын байгалийн цогцолборт газрын “Нүүдлийн болон суурин шувуудын судалгаа” -ааг 2014 оны 7 сарын 15-аас 11 сарын 15-ны хооронд хийв. Шувуудын ажиглалтыг Дарьганга сумын нутагт хамаарах Ганга, Дуут, Зэгст нуурууд болон Молцог элс, Алтан-Овоо-Дуут нуурыг хамруулан байгуулсан хамгаалалтын хашаан дахь таримал улиас, бургас, бүйлсний жижиг төгөлд 14 хоногт нэг удаагийн давтамжтайгаар ажиглалт явуулж тохиолдсон зүйлүүдийг бүртгэж, шаардлагатай үед тэдгээрийн зургийг авч баримтжуулан судалгааг гүйцэтгэсэн бөгөөд голлон Молцог элс болон түүний орчмын газруудад ажиглалтыг хийсэн болно. Судалгааны ажилд 7D маркын камер 100-400мм дуран, Orion 8x42 таталттай хоёр нүдний дуран, GPS, шувуу тодорхойлох бичиг болон С.Гомбобаатар нарын “Монгол орны шувуудын улаан данс” бүтээлийг тус тус ашиглав.



Зураг 1. Дарьгангын БЦГ-ийн газрын зураг.

Судалгааны үр дүн

Шувуудын ажиглалт судалгааны үр дүнд энэ нутгийн шувуудын зүйлийн бүрдэл жил бүр нэмэгдэж байна. Энэ удаагийн судалгаагаар 15 баг, 34 овог, 72 төрөлд хамаарах 100 зүйлийн шувууг Дарьгангын байгалийн цогцолборт газар бүртгэлээ (Хүснэгт 1). Эдгээр зүйлүүдийг харьцангуй элбэгшилээр нь хамаарах багт нь ангилж үзвэл Боршувуутаны баг хамгийн их буюу 49% эзэлж байгаа бол Хиазтан 12%, Шонхортон 9%, Галуутан 8%, Тогоруутан 4%, Тагтаатан т 4%, Уультаан 3%, Тахиатан 2%, Шунгууртан 2%, Өрөвтастан 2%, Хотонтон 1%, Хөхөөтөн 1%, Ураацайтан 1%, Өвөөлжтөн 1%, Тоншуултан 1% тус тус эзэлж байна (Зураг 2).




Зураг 2. Дарьгангын байгалийн цогцолборт газар тохиолсон нийт шувуудын зүйлүүдийг хамаарах багийн түвшинд харьцангуй элбэгшилээр нь харуулсан харьцуулалт.

Мөн Дарьгангын байгалийн цогцолборт газарт судалгаагаар бүртгэгдсэн 100 зүйлийн шувуудыг энэ нутагт оршин амьдрах хэлбэрээр нь ангилж үзвэл суурин амьдардаг шувууд 13% (n=13), зусдаг 11% (n=11), нүүдэллэн ирж өндөглөн зусдаг 22% (n=22), өвөлждөг 8% (n=8), нүүдлийн үедээ тохиолддог хамгийн олон буюу 46% (n=46) тус тус эзэлж байна (Зураг 3).




Зураг 3. Дарьгангын байгалийн цогцолборт газрын шувуудын оршин амьдрах хэлбэр.

Олон улсын байгаль хамгаалах холбооны гаргасан шалгуураар (IUCN, 2001) шувуудыг олон улс болон бүс нутгийн хэмжээнд хамгааллын статус, ховордлын зэрэглэлийг үнэлэн ангилсаны дагуу энэхүү судалгаанд тохиолдсон шувуудын зүйлүүдийн статусыг тодорхойлов. Олон улсын хэмжээнд авч үзвэл эмзэг 1 зүйл, ховордож болзошгүй 3 зүйл, анхааралд өртхөөргүй 96 зүйл шувуу байна. Харин бүс нутгийн хэмжээнд эмзэг 1 зүйл, ховордож болзошгүй 2 зүйл, үнэлгээ хийгдээгүй 1 зүйл, анхааралд өртхөөргүй 96 зүйл тус тус байна (Зураг 3 ба 4).



Зураг 4. Дарьгангын БЦГ-ын шувуудын олон улс дахь ховордлын зэрэг.



Зураг 5. Дарьгангын БЦГ-ын шувуудын бүс нутаг дахь ховордлын зэрэг.

Олон улсын болон бүс нутгийн хэмжээнд ховордлын түвшинд бүртгэгдсэн шувуудын зүйлүүдээс судалгааны явцад тохиолдсон байдлыг доорх хүснэгтэнд оруулав.

Хүснэгт 1. Дарьгангын БЦГ-т тохиолдох олон улсын болоод бүс нутгийн хэмжээнд ховордлын зэрэгт тооцогдох шувуудын зүйлүүд.

Олон улсын хэмжээнд			Бүс нутгийн хэмжээнд		
Латин нэр	Монгол нэр	Ховордлын зэрэг	Латин нэр	Монгол нэр	Ховордлын зэрэг
<i>Coturnix japonica</i>	Наран бөднө	Эмзэг	<i>Anser cygnoides</i>	Хошуу галуу	Эмзэг
<i>Anser cygnoides</i>	Хошуу галуу	Ховордож болзошгүй	<i>Falco cherrug</i>	Идлэг шонхор	Ховордож болзошгүй
<i>Falco cherrug</i>	Идлэг шонхор	Ховордож болзошгүй	<i>Grus vipa</i>	Цэн тогоруу	Ховордож болзошгүй
<i>Grus vipa</i>	Цэн тогоруу	Ховордож болзошгүй			

Энэхүү судалгаагаар тус бүс нутагт өмнө нь бүртгэж байгаагүй Цагаан дэвлээ (*Ardeola bacchus*), Хурган шунгуур (*Podiceps ruficollis*), Энхэт бялзуухай (*Bombycilla garrulus*), Хар тодол (*Sturnus vulgaris*), Дуулгат бужирга (*Fringilla coelebs*), Үүрэн сүүлт зана (*Uragus sibiricus*), Эгэл зана (*Pyrrhula perrhula*), Сондуу хөмрөг (*Emberiza chrysophrys*), Шар хөмсөгт хөмрөг (*Emberiza cioides*) зэрэг 9 зүйлийн шувууг бүртгэж, зургийн аван баталгаажуулан тархалтын цэгийг шинээр тэмдэглэсэнээрээ ихээхэн ач холбогдолтой ажил боллоо.

Цагаан дэвлээ (*Ardeola bacchus*) Bonaparte, 1855

Энэ зүйл шувууны нэг бодгаль нүүдлийн үедээ Дагшин булгийн Зэгст нууранд цутгах хэсэг буюу гүүрний орчимд өндөр ургамал ургасан, сондуул бүхий голын эрэгт 8 сарын 23-25 хооронд байршиж байв. Монгол оронд нүүдлийн үедээ ховор тохиолддог шувуу.



Зураг 6. Судалгааны үед тохиолдсон Цагаан дэвлээн ганц бодгаль. Зургийг С.Түвшинтөгс

Хурган шунгуур (*Podiceps ruficollis*) Pallas, 1764: Зэгст нууранд нэг хос амжилттай үржиж 2 дэгдээхэй бойжуулсан. Зуны турш тус нууранд байршиж байсан бөгөөд хамгийн сүүлд 11 сарын 9-ний ажиглалтаар зөвхөн дэгдээхэйнүүд нь бүртгэгдсэн. Монгол оронд одоогоор зөвхөн Хар-Ус нууран л үрждэг гэх мэдээ байгаа бөгөөд нүүдлийн үедээ Ихнууруудын хотгор, Хэнтийн уулархаг мужийн ус намгархаг газаруудад бүртгэгдсэн байна. Монгол оронд харьцангуй ховор тохиолдох энэ зүйл шувуу тус цогцолборт газрын Зэгст нууранд зусаж үржсэн нь ихээхэн сонирхолтой баримт юм.



Зураг 7. Судалгааны үед тохиолдсон Хурган шунгуур. Зургийг С.Түвшинтөгс

Хар тодол (*Sturnus vulgaris*) Linnaeus, 1758: Монгол орны баруун болон зүүн, төвийн хэсгээр өргөн тархалттай зүйл боловч энэ бүс нутагт өмнө нь судлаачид бүртгээгүй байна. 10 сарын 18нд Ганга нуурын урд хэсэг Баянбулаг орчимд хамгаалалтын торон хашаан дээр 10 гаран бодгаль бүхий сүрэг сууж байв.



Зураг 8. Судалгааны үед Ганга нуурын орчимд тохиолдсон Хар тодол. Зургийг С.Түвшинтөгс

Энхэт бялзуухай (*Bombycilla garrulus*) Linnaeus, 1758: Молцог элсний захаар 11 сарын 9нд ажиглалт хийхэд хүүхдийн зуслангийн баруун талын таримал хайлаасан төгөлд ганц бодгаль дуугаран сууж байв. Энэ орчимд өвөлжихөөр ирсэн үү, эсвэл оройтож нүүж яваа бодгаль уу гэдэг нь эргэлзээтэй. Цаашдын ажиглалтаар шалгах нь чухал юм.



Зураг 9. Судалгааны үед тохиолдсон Энхэт бялзуухайн ганц бодгаль. Зургийг С.Түвшинтөгс

Дуулгат бужирга (*Fringilla coelebs*) Linnaeus, 1758: Дарьгангын БЦГ-ын хамгаалалтын захиргааны хашааны орчимд 11 сарын 11нд нэг хос газраас хооллож байхтай таарав. Энэ нутагт өвөлжихөөр ирэв үү эсвэл дайрч өнгөрч байгаа эсэх нь эргэлзээтэй.



Зураг 10. Судалгааны үед тохиолдсон Дуулгат бужирга. Зургийг С.Түвшинтөгс

Үүрэн сүүлт зана (*Uragus sibiricus*) Pallas, 1773: Молцог элсний хөвөөгөөр ургасан бургас хайлаасанд 11 сарын 1 ба 9-ний өдрүүдэд шувуудын ажиглалт хийхэд уг зүйл шувуу нийт 20 орчим тоотой ажиглагдав. Энэ орчимд үүрэн сүүлт зана сүүлийн 2 жил тогтмол өвөлжиж байна.



Зураг 11. Судалгааны үед Молцог элсэнд тохиолдсон Үүрэн сүүлт зана. Зургийг С.Түвшинтөгс

Эгэл зана (*Pyrhula perrhula*) Linnaeus, 1758: Молцог элсний захаар 11 сарын 9нд ажиглалт хийхэд шигүү ургасан бургасантөгөлд ганц эм бодгаль ажиглагдав. Энэ орчимд өвөлжихөөр ирсэн байх боломжтой.



Зураг 12. Судалгааны үед Молцог элсэнд тохиолдсон Эгэл занын эм шувуу. Зургийг С.Түвшинтөгс

Сондуу хөмрөг (*Emberiza chrysophrys*) Pallas, 1776: Дарьгангын БЦГ-ын хамгаалалтын захиргааны байрны хашаан дахь хайлаасанд 9 сарын 2 нд нэг хос өдөржин байршиж байв. Нүүдлийн үедээ энэ бүс нутгаар дайрч өнгөрч байгаагаар тохиолдов.



Зураг 13. Судалгааны үед тохиолдсон Сондуу хөмрөг. Зургийг С.Түвшинтөгс

Шар хөмсөгт хөмрөг (*Emberiza cioides*) Brandt, 1843: Ганга нуур орчмын элс эмжиж ургасан бургасанд 11 сарын 19-ны ажиглалтаар маш олон тоогоор тохиолдож байв. Нүүдлийн үедээ дамжин өнгөрдөг зүйл.



Зураг 14. Судалгааны үед Ганга нуур орчмын бургаст нугаар тохиолдсон Шар хөмсөгт хөмрөг. Зургийг С.Түвшинтөгс

Хүснэгт 2. Дарьгангын байгалийн цогцолборт газарт уг судалгаагаар бүртгэгдсэн шувуудийн зүйлийн бүрдэлийн жагсаалт. Зөвхөн тус бүс нутагт тохиолдох байдлаар нь доорх байдлаар ангилсан болно. 3-зусдаг, С-суурин, НТ-нүүдлийн үедээ тохиолддог, Ү-үрждэг, Ө-өвөлждөг.

№	Латин нэр	Монгол нэр	С	Ү	НТ	З	Ө
1	<i>Perdix dauurica</i>	Дагуур ятуу		+			
2	<i>Coturnix japonica</i>	Наран бөднө		+			
3	<i>Anser cygnoides</i>	Хошуу галуу			+		
4	<i>Cygnus cygnus</i>	Гангар хун		+			
5	<i>Todorna feruginea</i>	Хондон ангир		+			
6	<i>Todorna todorna</i>	Анхидал ангир		+			
7	<i>Anas strpera</i>	Бор нугас		+			
8	<i>Aythya ferina</i>	Улаанхүзүүт шумбуур				+	
9	<i>Aythya fuligula</i>	Гэээгт шумбуур		+			
10	<i>Bucephala clangula</i>	Алаг шунгаач			+		
11	<i>Podiceps nigricollis</i>	Халтар шунгуур			+		
12	<i>Podiceps ruficollis</i>	Хурган шунгуур		+			
13	<i>Ardeola bacchus</i>	Цагаан дэвлээ			+		
14	<i>Ardea cinerea</i>	Хөх дэглий				+	
15	<i>Phalacrocorax carbo</i>	Тураг гогой			+		
16	<i>Falco tinnunculus</i>	Начин шонхор					+
17	<i>Falco amurensis</i>	Амарын шонхор		+			
18	<i>Falco cherrug</i>	Идлэг шонхор			+		
19	<i>Milvus migrans</i>	Сохор элээ				+	
20	<i>Circus spilonotus</i>	Дорны хулд		+			
21	<i>Circus cyaneus</i>	Саарал хулд			+		
22	<i>Accipiter gentilis</i>	Үлэг харцага					+
23	<i>Buteo hemilasius</i>	Шилийн сар	+				
24	<i>Aquila nipalensis</i>	Хээрийн бүргэд			+		
25	<i>Porzana pusilla</i>	Оодон түнжгэр		+			
26	<i>Fulica atra</i>	Халзан түнжүү		+			
27	<i>Grus vipo</i>	Цэн тогоруу			+		
28	<i>Anthropoides vigro</i>	Өвөгт тогоруу		+			
29	<i>Himantopus himantopus</i>	Хилэн жигүүр				+	
30	<i>Recurvirostra avosette</i>	Алаг ээтэн				+	
31	<i>Vanellus vanellus</i>	Умардын хавтгаалж		+			
32	<i>Charadrius dubius</i>					+	
33	<i>Gallinago gallinago</i>	Шөвгөн хараалж			+		
34	<i>Tringa erythropus</i>	Хар хөгчүү			+		
35	<i>Tringa totanus</i>	Улаан хөлт хөгчүү				+	
36	<i>Tringa ochropus</i>	Сүүл цагаан хөгчүү				+	
37	<i>Actits hypoleucos</i>	Эгэл хайргийн хөгчүү			+		
38	<i>Larus mongolicus</i>	Үхэр цахлай				+	
39	<i>Sterna hirundo</i>	Эгэл хараалай			+		
40	<i>Chlidonias leucopterus</i>	Буурал хараалай			+		
41	<i>Syrhaptus paradoxus</i>	Монгол ногтруу	+				
42	<i>Columba livia</i>	Хадны тагтаа	+				

43	<i>Streptopelia orientalis</i>	Дорны хүүрзгэнэ			+		
44	<i>Streptopelia decaocto</i>	Буулгат хүүрзгэнэ				+	
45	<i>Cuculus canorus</i>	Эгэл хөхөө					+
46	<i>Bubo bubo</i>	Эгэл шаршувуу	+				
47	<i>Athene noctua</i>	Хотны бүгээхэй	+				
48	<i>Asio otus</i>	Соотон гуйванга					+
49	<i>Apus pacificus</i>	Хондлой цагаан ураацай	+				
50	<i>Upupa epops</i>	Бөөвөлжин өвөөлж		+			
51	<i>Jynx torquilla</i>	Холтсон гоётуул			+		
52	<i>Lanius cristatus</i>	Ухаа дунхай			+		
53	<i>Pica pica</i>	Алаг шаазгай	+				
54	<i>Pyrhocorax pyrrhocorax</i>	Улаан хошуут жунгаа	+				
55	<i>Corvus dauuricus</i>	Алагтуу		+			
56	<i>Corvus corone</i>	Хар хэрээ		+			
57	<i>Corvus corax</i>	Хон хэрээ		+			
58	<i>Bombycilla garrulus</i>	Энхэт бялзуухай			+		
59	<i>Hirundo rustica</i>	Алтан хараацай		+			
60	<i>Mylanocorypha mongolica</i>	Монгол болжмор	+				
61	<i>Calandrella cheleensis</i>	Дэрсний жиргэмэл		+			
62	<i>Eremophila alpestris</i>	Шоорон эвэрт болжмор	+				
63	<i>Locustella lanceolata</i>	Бидэрт шатан сүүлт			+		
64	<i>Locustella certhiola</i>	Гүймхий шатан сүүлт			+		
65	<i>Phylloscopus proregulus</i>	Жирхэн дууч шувуу			+		
66	<i>Phylloscopus borealis</i>	Умардын дууч шувуу			+		
67	<i>Phylloscopus trochiloides</i>	Ногоовор дууч шувуу			+		
68	<i>Sylvia curruca</i>	Тарчигнаа зэржигэнэ			+		
69	<i>Sturnus vulgaris</i>	Хар тодол			+		
70	<i>Sturnus cineraceus</i>	Бор тодол				+	
71	<i>Turdus naumanni</i>	Науманы хөөндэй			+		
72	<i>Luscinia calliope</i>	Өнгөлүүрт гургалдай			+		
73	<i>Tarsiger cyanurus</i>	Хөх зоот гургалдай			+		
74	<i>Phoenicurus phoenicurus</i>	Эгэл гал сүүлт			+		
75	<i>Phoenicurus aureus</i>	Дагуур гал сүүлт			+		
76	<i>Saxicola torquatus</i>	Эгэл шулганаа			+		
77	<i>Oenanthe oenanthe</i>	Адууч чогчиго		+			
78	<i>Oenanthe isabellina</i>	Бүжимч чогчиго			+		
79	<i>Muscicapa dauurica</i>	Дагуур намнаахай			+		
80	<i>Passer domesticus</i>	Оронгийн бор шувуу	+				
81	<i>Passer montanus</i>	Хээрийн бор шувуу	+				
82	<i>Petronia petronia</i>	Хадны бор шувуу	+				
83	<i>Prunella montanella</i>	Сибирь хайруулдай			+		
84	<i>Motacilla alba</i>	Хөх цэгцгий			+		
85	<i>Motacilla citreola</i>	Шар түрүүт цэгцгий	+				
86	<i>Motocilla flava</i>	Шар цэгцгий			+		
87	<i>Motocilla cinerea</i>	Уулын цэгцгий			+		
88	<i>Anthus spinoletta</i>	Харзны шийхнүүхэй			+		
89	<i>Fringilla coelebs</i>	Дуулгат бужирга					+
90	<i>Fringilla montifringilla</i>	Алаг бужирга			+		

91	<i>Carduelis flammea</i>	Дөлөн цэгцүүхэй					+
92	<i>Coccothraustes coccothraustes</i>	Банхар болжуухай			+		
93	<i>Uragus sibiricus</i>	Үүрэн сүүлт зана					+
94	<i>Pyrrhula perrhula</i>	Эгэл зана					+
95	<i>Emberiza leucocephalos</i>	Цагаан шанаат хөмрөг			+		
96	<i>Emberiza cioides</i>	Шар хөмсөгт хөмрөг			+		
97	<i>Emberiza pusilla</i>	Борлог хөмрөг			+		
98	<i>Emberiza chrysophrys</i>	Сондуу хөмрөг			+		
99	<i>Emberiza spodocephala</i>	Хөх түрүүт хөмрөг			+		
100	<i>Emberiza pallasii</i>	Цагаан хэвэлт хөмрөг			+		
Бүгд			13	22	46	11	8
			100				

Хээрийн судалгааны цэгүүдэд тохиолдсон зарим шувууд. Доорх бүх шувуудын зургийг судалгааны үед дарсан бөгөөд зургийг дарсан С.Түвшинтөгс.

Галуутаны багийн шувууд




Гангар хун (*Cygnus cygnus*)




Анхидал ангир (*Tadorna tadorna*)



Хондон ангир (*Tadorna feruginea*)



Бор нугас (*Anas strepera*)



Гэээгт нугас (*Aythya fuligula*)




Улаанхүзүүт шумбуур (*Aythya ferina*)

Шонхортоны багийн шувууд




Амарын шонхор (*Falco amurensis*)



Сохор элээ (*Milvus migrans*)



Дорнын хулд (*Circus spilonotus*)



Үлэг харцага (*Accipiter gentilis*)

Тогоруутаны багийн шувууд



Өвөгт тогоруу (*Anthropoides vigro*)



Цэн тогоруу (*Grus vipo*)



Халзан түнжүүр (*Fulica atra*)

Хиазтаны багийн шувууд



Алаг ээтэн (*Recurvirostra avosette*)



Хилэн жигүүр (*Himantopus himantopus*)



Умардын хавтгаалж (*Vanellus vanellus*)



Нарийн хиазат (*Charadrius dubius*)



Хар хөгчүү (*Tringa erythropus*)



Эгэл хараалай (*Sterna hirundo*)

Тагтаатаны багийн шувууд



Хадны тагтаа (*Columba livia*)



Буулгат хүүрзгэнэ (*Streptopelia decaocto*)

Уультаны багийн шувууд



Хотны бүгээхэй (*Athene noctua*)



Соотон гуйванга (*Asio otus*)

Өрөвтастаны багийн шувуу



Хөх дэглий (*Ardea cinerea*)

Тоншуултаны багийн шувуу



Холтсон гоётуул (*Jynx torquilla*)

Бор шувуутан



Алаг шаазгай (*Pica pica*)



Улаан хошуут хэрээ (*Pyrrhocorax pyrrhocorax*)



Алагтуу хэрээ (*Corvus dauuricus*)



Шоорон эвэрт болжмор (*Eremophila alpestris*)



Гүймхий шатан сүүлт (*Locustella certhiola*)



Бидэрт шатан сүүлт (*Locustella lanceolata*)



Жирхэн дууч шувуу (*Phylloscopus proregulus*)



Умардын дууч шувуу (*Phylloscopus borealis*)



Улаан гүеэт хөөндэй (*Turdus ruficollis*)



Науманы хөөндэй (*Turdus naumanni*)



Өнгөлүүрт гургалдай (*Luscinia calliope*)



Хөх зоот гургалдай (*Tarsiger cyanurus*)



Дагуур гал сүүлт (*Phoenicurus aureus*)



Эгэл гал сүүлт (*Saxicola torquatus*)



Хээрийн бор шувуу (*Passer montanus*)



Дагуур намнаа (*Muscicapa dauurica*)



Хадны бор шувуу (*Petronia petronia*)



Сибирь хайруулдай (*Prunella montanella*)



Шар түрүүт цэгцгий (*Motacilla citreola*)



Уулын цэгцгий (*Motacilla cinerea*)



Хөх цэгцгий (*Motacilla alba*)



Алаг бужирга (*Fringilla montifringilla*)

Дүгнэлт

Энэхүү судалгаагаар Дарьгангын БЦГ-т нийт 100 зүйлийн шувуудыг тэмдэглэлээ. Жил бүрийн ажиглалт судалгааны үр дүнд шинээр шувууд бүртгэгдсээр байгаа ба цаашдын судалгаагаар ч нэмэгдэх хандлагатай. Энэ жилийн хувьд Цагаан дэвлээ, Хурган шунгуур, Энхэт бялзуухай, Хар тодол, Дуулгат бужирга, Үүрэн сүүлт зана, Эгэл зана, Сондуу хөмрөг, Шар хөмсөгт хөмрөг зэрэг 9 зүйлийн шувууг шинээр бүртгээд байна.

Нийт шувуудын 50 орчим хувийг боршувуутаны багийн шувууд бүрдүүлдэг. Харин оршин амьдрах хэлбэрийн хувьд нүүдлийн үедээ тохилддог буюу дамжин өнгөрдөг зүйлүүд хамгийн их хувийг эзэлж байна. Энэ нь тус бүс нутаг дахь амьдрах орчны олон янз байдал нь олон зүйлийн нүүдлийн шувуудын хувьд дамжин өнгөрөх чухал нутаг болхыг илтгэж байна. Ялангуяа олон улсын болоод бүс нутгийн хэмжээнд ховорт тооцогдож байгаа цэн тогоруу, хошуу галуу, хонин тоодог, морин цууцал зэрэг шувуудын нүүдлийн замын түшиц нутаг болж байна.

Санал зөвлөмж

Дарьгангын байгалийн цогцолборт газарт хийсэн “Нүүдлийн болоод суурийн шувуудын судалгаа” -гаар дараах санал, зөвлөмжийг гаргаж байна.

1. Нүүдлийн шувуудын ажиглалт, судалгааг тэдгээрийн идэвхитэй үе болох хавар намрын улиралд тогтмол хийж байх.
2. Ховор махчин шувуудын үржлийг дэмжих зорилгоор тохиромжтой газаруудад хиймэл үүр хийж байрлуулах, гөрөөл амьтан хараачлах суудал зэргийг босгох.
3. Шувуу ажиглах, хамгаалах арга хэмжээг олон нийтэд сурталчилах
4. Моцог элсэнд ургах жимс, жимсгэнэ бүхий мод буттай хэсгийг хамгаалах эсвэл жимс бүхий модтой төгөл бий болгох. Ингэснээр тус нутагт ховор тохиолдох зарим шувуудын амжилттай нүүдэллэхэд дэм болох учиртай.

Ашигласан бүтээл

1. Гомбобаатар, С., Жаргалсайхан, П. 2011. Хурх-Хүйтэний хөнлийн шувууд. Монголын шувуу судлалын нийгэмлэг, Монгол улсын их сургууль, Байгаль орчин аялал жуулчлалын яам. Улаанбаатар хот, Монгол улс.
2. Ганхуяг, П., Э. Болормөнх, ба Г. Амархүү. 2013. Ганга нуур ба түүний орчмын шувуудын намрын нүүдлийн ажиглалтын үр дүнгээс. Байгаль орчин амьдрал сэтгүүл. Улаанбаатар.
3. Жаргалсайхан, П. 2011. Монгол орны нүүдлийн шувуудын судалгаанд. Магистерийн зэрэг горилсон бүтээл. Улаанбаатар.
4. Цэгмид, Ш. 1969. Монгол орны физик газарзүй. Улсын хэвлэлийн газар, Улаанбаатар.
5. Цэвээнмядаг, Н., Б. Дашням, Д. Батчулуун, ба Х. Бодьсайхан. 2012. Шувууны томууг тандах судалгааны тайлан 2009-2011. Улаанбаатар.
6. Шар С., Самъяа Р., Гомбобаатар С., Цэвээнмядаг Н., Цагаанцоож Н., Тунгалаг Р., 2008. Богдхан уул, түүний орчмын зонхилох амьтан ургамал. Улаанбаатар
7. Gombobaatar, S. and Monks,E.M. (compilers), Seidler, R., Sumiya, D., Tseveenmyadag, N., Bayarkhuu, S., Baillie, J.E.M., Boldbaatar, Sh., Uuganbayar, Ch. (editors) (2011). Regional Red List Series Vol.7. Birds. Zoological Society of London, National University of Mongolia and Mongolian Ornithological Society.